



**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

**Бодлогын чиглэл батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэг, Даргын зөвлөлийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсад телевизийн нэвтрүүлэг, аудио, видео санг интернэтээр дамжуулах үйлчилгээ эрхлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх баримтлах чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.


3. Энэхүү баримтлах чиглэл батлагдсантай холбогдуулан Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2009 оны 111 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсад интернет протоколд суурилсан телевиз (IPTV)-ийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл”-ийн 2.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Баримтлах чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус газрын Радио, телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлого, зохицуулалтын газар /А.Золзаяа/-т даалгасугай.

ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ



Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын  
2020 оны 09 сарын 14-ны өдрийн 1р тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛЭГ,  
АУДИО, ВИДЕО САНГ ИНТЕРНЭТЭЭР ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсад телевизийн нэвтрүүлэг<sup>1</sup>, аудио сан, видео сан (телевизийн суваг, LIVE TV<sup>2</sup>, VoD<sup>3</sup>, AoD<sup>4</sup>)-г интернэт (public internet)-ээр дамжуулах үйлчилгээ (цаашид “интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ” гэх) эрхлэхэд баримтлах чиглэлийг тодорхойлно.

1.2. Интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү баримтлах чиглэлийг баримтална.

1.3. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон Харилцаа холбооны зохицуулах хороо дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү баримт бичгийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хоёр. Интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэхэд баримтлах чиглэл

2.1. Тухайн үйлчилгээнд хамаарах үндэсний болон олон улсын стандарт, Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-аас гаргасан зөвлөмжийг мөрдлөг болгоно.

2.2. Монгол Улсын хуулиар хориглоогүй, албан ёсны эрхтэй контентоор үйлчилгээ үзүүлнэ.

2.3. Интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хуульд зааснаас бусад тохиолдолд хэрэглэгчийн төхөөрөмжийн төрөлд хязгаарлалт тавихгүй байна.

2.4. Интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч нь хуульд зааснаас бусад тохиолдолд интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээг дамжуулахдаа интернэт хурдны болон бусад хязгаарлалт хийхгүй.

2.5. Интернэтээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь зохиогчийн бүтээл, хэрэглэгчийн бүртгүүлсэн мэдээллийг хамгаална.

<sup>1</sup> Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.10. ""

<sup>2</sup> Телевизийн шууд дамжуулал;

<sup>3</sup> Видео контент агуулсан сангаас хэрэглэгчийн захиалгат контентыг хүргэх үйлчилгээ;

<sup>4</sup> Аудио контент агуулсан сангаас хэрэглэгчийн захиалгат контентыг хүргэх үйлчилгээ;

2.6. Интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээндээ насны хязгаар тохируулах, хүүхдийг зохисгүй контентоос хамгаалах, эцэг эхийн хяналт хийх техникийн боломжийг бүрдүүлнэ.

2.7. Интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь төрөөс иргэдэд хүргэх радио, телевизээс бусад тусгай зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш радио, телевизийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх тохиолдолд тусгай зөвшөөрөл авна.

2.8. Интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхэлж байгаа этгээд нь энэхүү баримтлах чиглэлийн 2.7-д заасан тусгай зөвшөөрлийг Зохицуулах хорооноос олгох хүртэл уг үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлж болно.

2.9. Энэхүү баримт бичгийн 2.7-д зааснаас бусад интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлнэ.

Гурав. Интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээний зохицуулалтад баримтлах чиглэл

3.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээнд дараах чиглэлийг баримтална.

3.1.1. Энэхүү баримт бичгийн 2.7-д заасан тусгай зөвшөөрлийг олгохдоо интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагыг тусгайлан тогтоож, мөрдүүлнэ.

3.1.2. Интернетээр дуу, дүрс дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоонд хязгаарлалт тавихгүй.

---oOo---



Боловсруулсан  
Нийлсэн.  
Хувь:  
2000 он 09 сар 14 дор

Ч. Болор-Эрдэнэ